- Монгол Улсын 2020 оны Төсвийн тухай хууль
- Эрүүл мэндийн тухай хууль

## 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Эрүүл мэндийн яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

## 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3 дугаар улирлын үр дүнгийн тайлангийн нийт зардал 7068282.0 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 70682.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 9884675.8 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 98846.8 мянган төгрөгөөр тооцов.

## 3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2413146.5 мянган төгрөгөөр буюу 19.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 601,623.7 | 891,123.9 | 289,500.2 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 5,283.8 | 7,220.7 | 1,936.9 |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 596,339.9 | 883,903.3 | 287,563.4 |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 11,808,465.4 | 13,932,111.7 | 2,123,646.2 |
| Үндсэн хөрөнгө | 16,252,270.5 | 18,969,974.1 | 2,717,703.6 |
| Хуримтлагдсан элэгдэл | (4,443,805.1) | (5,037,862.5) | (594,057.4) |
| **Нийт хөрөнгө** | 12,410,089.1 | 14,823,235.6 | 2,413,146.5 |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 12,410,089.1 | 14,823,235.6 | 2,413,146.5 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 12,410,089.1 | 14,823,235.6 | 2,413,146.5 |

Авлага дансны үлдэгдэл 7220.7 мянган төгрөг болж 1936.9 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл 1936.9 мянган төгрөгийг төвлөрүүлж авлагаар бүргэсэнтэй холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2017-2018 онуудад үүссэн, 5283.8 мянган төгрөгийн авлага байгаа нь татаас санхүүжилтийн авлага 967.8 мянга, хувь хүнээс авах авлага 816.0 мянга, байгууллагаас авах авлага 3500.0 мянган төгрөг байна.

Нийт авлагаас хугацаандаа барагдах боломжгүй эрсдэлтэй 5283.8 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь 2017 оны жилийн эцсийн нэмэлт санхүүжилтийн дансны төвлөрүүлсэн үлдэгдэл 967.8 мянга, 2017 онд кассаар ажиллаж байсан ажилтантай холбоотой 816.0 мянга, 2018 онд амбулаторийн барилгын зураг төсвийн үнэ 3500.0 мянган төгрөгийг “Голом өргөө” ХХК-д шилжүүлж авлагаар тусгасан ч яамнаас өөр зураг төсөв хийгдэж тендер зарлагдан барилгын ажил хийгдсэнтэй холбоотой авлагууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 883903.3 мянган төгрөг болж 287563.4 мянган төгрөгөөр өссөн нь эм, эмнэлгийн хэрэгслийн дансны үлдэгдэл өмнөх оноос 190053.3 мянган төгрөгөөр нэмэгдэж цар тахлын үед бэлэн байдлыг хангах зорилгоор 37958.8 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй, 185484.9 мянган төгрөгийн эм эмнэлгийн хэрэгслийг төсвийн хөрөнгөөр худалдан авсан нь голлох нөлөөг үзүүлж байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 18969974.1 мянган төгрөг болж 217703.6 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 115264.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, хандив тусламжаар 2677850.9 мянга төгрөгийн хөрөнгө бүртгэж, 65679.6 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авч, 60184.5 мянган төгрөгийн хөрөнгө актлан, 80906.3 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 1042948.6 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 115264.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 1700581.8 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй шилжүүлсэн 80906.3 мянган төгрөг, акталсан 60184.5 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө данс 1494.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 1500.0 мянган төгрөгийн веб сайт хийлгэж, 2994.0 мянган төгрөгийн ашиглалтгүй программ хангамж акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14823.2 мянган төгрөг болж 2413146.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 2413146.5 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 12297822.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 376098.9 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын өөрийн орлого, тусламж санхүүжилтийн орлого байна. Төсөв байгууллагын өөрийн орлого өмнөх оноос 863034.4 сая төгрөгөөр буурсан нь үндсэн үйл ажиллагааны орлого 28682.9 мянган төгрөгөөр нэмэгдэж үнэ төлбөргүй хүлээж авсан орлого 891717.3 мянган төгрөгөөр буурсантай, тусламж санхүүжилтийн орлого 1239133.2 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь урсгал үйл ажиллагааны санхүүжилт 499514.6 мянга, Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилт 4516052.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, нэмэлт санхүүжилтийн дансанд ажилчдын 5 жилийн тэтгэмж 119719.4 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөөг үзүүлж байна.

Нийт зардал 9883716.1 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 1022051.6 мянган төгрөгөөр буюу 11.5 хувиар өссөн буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардал нэмэгдсэнтэй холбоотой байна

### 3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 9538570.3 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 9538570.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 383800.5 мянган төгрөгөөр бууруулж 9154769.8 мянган төгрөгөөр баталсан байна.

**Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 9154769.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 4440643.2 мянган төгрөгийг улсын төсвөөс 4517894.9 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас 196231.7 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4440643.2 мянга, эрүүл мэндийн даатгалын сангаас 4516052.6 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 183553.8 мянган төгрөг, нийт 9140249.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 9137973.3 мянган төгрөгийг зарцуулж 2276.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 9137973.3 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь цалингийн зардлыг 11725.7 мянга, байр ашиглалттай холбоотой тогтол зардлыг 3147.6 мянга, хангамж бараа материалын зардлыг 630.9 мянга, нормативд зардлыг 39.9 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 118.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1129.1 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 71602 хөтөлбөрийн 80101 арга хэмжээ 15711.6 мянган төгрөгөөр, 80219 арга хэмжээ 1080.0 мянган төгрөгөөр, 80802 арга хэмжээ 4.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

| ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|
| ХӨТӨЛБӨР 71602 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,952,113,200.00 | 8,936,401,549.07 | 15,711,650.93 | 99.82 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 8,952,113,200.00 | 8,936,401,549.07 | 15,711,650.93 | 99.82 |
| Бараа, үйлчилгээний зардал | 8,952,113,200.00 | 8,936,401,549.07 | 15,711,650.93 | 99.82 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 5,279,442,200.00 | 5,267,716,464.00 | 11,725,736.00 | 99.78 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 712,724,600.00 | 712,724,600.00 | - | 100.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 900,864,500.00 | 897,716,944.00 | 3,147,556.00 | 99.65 |
| Хангамж, бараа материалын зардал | 179,519,500.00 | 178,888,632.00 | 630,868.00 | 99.65 |
| Норматив зардал | 1,635,996,800.00 | 1,635,956,949.07 | 39,850.93 | 100.00 |
| Эд хогшил худалдан авах | 176,640,800.00 | 176,522,240.00 | 118,560.00 | 99.93 |
| Томилолт, зочны зардал | 10,681,500.00 | 10,681,500.00 | - | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 56,243,300.00 | 56,194,220.00 | 49,080.00 | 99.91 |
| ХӨТӨЛБӨР 71602 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 80219 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 25,200,000.00 | 24,120,000.00 | 1,080,000.00 | 95.71 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 25,200,000.00 | 24,120,000.00 | 1,080,000.00 | 95.71 |
| Бараа, үйлчилгээний зардал | 25,200,000.00 | 24,120,000.00 | 1,080,000.00 | 95.71 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 25,200,000.00 | 24,120,000.00 | 1,080,000.00 | 95.71 |
| ХӨТӨЛБӨР 71602 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 80802 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 6,240,000.00 | 6,235,200.00 | 4,800.00 | 99.92 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 6,240,000.00 | 6,235,200.00 | 4,800.00 | 99.92 |
| Бусад урсгал шилжүүлэг | 6,240,000.00 | 6,235,200.00 | 4,800.00 | 99.92 |
| ХӨТӨЛБӨР 71602 | - | - | - | - |
| АРГА ХЭМЖЭЭ 81611 | - | - | - | - |
| I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 171,216,600.00 | 171,216,600.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 171,216,600.00 | 171,216,600.00 | - | 100.00 |
| Бараа, үйлчилгээний зардал | 171,216,600.00 | 171,216,600.00 | - | 100.00 |
| Норматив зардал | 171,216,600.00 | 171,216,600.00 | - | 100.00 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Эрүүл мэндийн даатгалын сангаас 202100.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 5279.5 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 119719.4 мянга, тендерийн баримт бичгийн үнэ 105.0 мянга, нийт 327203.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс ажилчдын 5 жилийн тэтгэмжид 119719.4 мянга, “Жаргалтай амьдрал” төвийн цалинд 4981.2 мянга, шагнал урамшуулалд 74427.0 мянга, бусад урсгал төсвийн зардалд 126139.4 мянга нийт 325267.0 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1936.9 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 161 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулсан байна.

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 9 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 2 | | |
| 4 | Сар бүр | 5 | 46 | 34 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 96 | | |
| | Нийт | 29 | 161 | 145 | 0 | 2 |

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1819.1 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 306.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар 4312.5 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 1819.1 | 2 | 1819.1 | - | - | |
| Албан шаардлага | 1 | 306.9 | 1 | 306.9 | - | - | |
| Зөвлөмж | 3 | 4312.5 | 3 | 4312.5 | - | - | |
| Нийт дүн | 7 | 6438.5 | 7 | 6438.5 | - | - | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 15521.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 3118.3 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 10664.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүлж, 1738.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

## Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 13782.4 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 3118.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 10664.1 мянган төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэст 5 албан хаагчийн цалинг 4207207 төгрөгөөр илүү, 3 албан хаагчийн цалинг 1173089 төгрөгөөр дутуу буюу нийт цалингийн санг 5380296 төгрөгөөр зөрүүтэй мэдээлсэн нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалтыг зөрчсөн, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

    Шийдвэрлэсэн нь: Нийгмийн даатгалын хэлтэст зөрүүтэй мэдээлсэн ажилчдын цалинг залруулж мэдээлж зөрчлийг арилгах албан шаардлага өгөх.

2. Тус байгууллагын авлагын дансны үлдэгдэл 7220.07 мянган төгрөг байгаа баа үүнээс 1936.9 мянган төгрөг нь тайлант онд үүсэн нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн үлдэгдлийг оны эцэст төвлөрүүлсэнтэй холбоотой үүссэн бол 5283.8 мянган төгрөг нь 2017-2018 онуудад үүсэн 2-3 жилийн насжилттай авлагын үлдэгдэл байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалттай нийцэхгүй, "Эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

    Шийдвэрлэсэн нь: Өмнөх онуудад үүссэн олон жилийн насжилттай авлагын үлдэгдлийг барагдуулах асуудлыг холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлүүлэх албан шаардлага өгөх.

3. Эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдээс нийлүүлсэн худалдан авалтыг түүвэрлэн гэрээний үнэтэй тулган шалгахад нийт 8 аж ахуйн нэгжээс 11917ш эм эмнэлгийн хэрэгслийг гэрээний үнээс 3118.3 мянган төгрөгөөр илүү үнээр худалдан авсан байна. нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалттай нийцэхгүй, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

    Шийдвэрлэсэн нь: Гэрээний нөхцөлийг мөрдөөгүйгээс төсвөөс илүү зарцуулсан 3118.3. мянган төгрөгийг бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүд (*"Ази фарм" ХХК-109.5 мянга, "Интер сайнс" ХХК-307.3 мянга, "Монгол фарм" ХХК-104.0 мянга, "Монфа трейд" ХХК-150.0 мянга, "Мөнхийн түн" ХХК-139.2 мянга, "Сетунари" ХХК-188.5 мянга, "Тавин-Ус" ХХК-1605.0 мянга, "Чоно гол" ХХК-514.8 мянга*)-аар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэв

## Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1738.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар тушаалаар баталсан "Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах журам"-ын дагуу тайлант ЭМД-ын сангаас нэмэлт дансаар 202100.0 мянган төгрөг хүлээн авсныг үзүүлсэн үйлчилгээний тоо, төлбөрийн хэмжээтэй харьцуулан үзэхэд цаг хугацааны хувь боломжгүй байсан тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:* Байгууллагын бэлэн мөнгөний кассын дансаар 2020 оны 12 дугаар сарын 25-31-ны өдрүүдэд орсон 1229.1 мянган төгрөгийн орлогыг санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн.

*1.2.* *Эрсдэл:* Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь тухайн байгууллагын онцлог, үйл ажиллагаатай уялдаагүй байх

*1.3.* *Өгсөн зөвлөмж:*Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын онцлог, үйл ажиллагаанд уялдуулан шинэчилж Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

*1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

### 2. *Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэлтэй холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:* Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар тушаалаар баталсан "Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах журам"-ын дагуу тайлант ЭМД-ын сангаас байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд 202100.0 мянган төгрөг санхүүжүүлснийг байгууллагын хамт олны хурлаар баталсан журмын дагуу 74427.0 мянган төгрөгийн алба хаагчдын урамшуулалд зарцуулж, 124869.9 мянган төгрөг буюу 61.8%-ийг тоног төхөөрөмж, эд хогшил, урсгал засвар, эргэлтийн хөрөнгө гэх мэт байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогыг, зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3 дахь “үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулахыг хориглоно.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

*2.2. Эрсдэл:* Төсвийн байгууллагын үйл ажиллагааны орлогыг төлөвлөөгүйгээс төсөвт тусгагдаагүй арга хэмжээнд төсвийн хөрөнгө зарцуулж төсвийн хөрөнгөд тавих хяналтыг сулруулж, үрэлгэн зардал бий болох.

*2.3. Өгсөн зөвлөмж* Цаашид төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, “Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг”-ийн орлогыг жил бүр төсвийн орлогын бүрэлдэхүүнд оруулан төлөвлөж, Төсвийн тухай хуулийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үйл ажиллагааны нэмэлт орлогыг, зарцуулах тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах

*2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

### 3. *Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал*

*3.1. Илрүүлэлт:* Байгууллагын бэлэн мөнгөний кассын тайлангаарх орлого зарлагын гүйлгээг тулган шалгахад тайланд хугацаанд нийт 59 өдрийн 30063.2 мянган төгрөгийн орлого буюу дунджаар 509.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг дараагийн ажлын өдөрт багтаан төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын мөнгөн кассын үйл ажиллагааны журам”-ын 2.6 дахь “*Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах*

*эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана."* гэсэн заалттай нийцэхгүй байна.
*3.2. Эрсдэл:* Кассын дансны үлдэгдэлд тавих хяналт хангалтгүй
*3.3. Өгсөн зөвлөмж:* Кассад орсон орлогыг дараагийн ажлын өдөрт багтаан төрийн сангийн дансанд төвлөрүүлж, кассын үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах
*3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

***4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал***

*4.1. Илрүүлэлт:* Тайлан онд байгууллагын дарга нь эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэгч жижүүр эмчийн байхгүй хугацаанд тус үүргийг давхар гүйцэтгэхдээ жижүүрийн хуваарийг өөрөө баталсан байна.
*4.2. Эрсдэл:* Хуулийг бүрэн хэрэгжүүлээгүйгээс ашиг сонирхлын зөрчил үүсэх.
*4.3. Өгсөн зөвлөмж:* Цаашид төсвийн захирагч нь зайлшгүй нөхцөл байдлын улмаас гүйцэтгэх албан үүрэг давхар гүйцэтгэхдээ холбогдох шийдвэрийг эмчилгээ эрхэлсэн орлогчоор гаргуулж Нийтийн албанд нийтийн болон хувийг ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах.
*4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.*

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ:

Бэлтгэсэн:

АУДИТОР ............................................................ Ж.ӨСӨХБАЯР
Огноо: 2021.02.01

Анхан шатанд хянасан:

ХЭЛТСИЙН ДАРГА БӨГӨӨД АУДИТЫН МЕНЕЖЕР............................................ А.ЦЭЭНЯМ
Огноо: 2021.02.01

Хоёр дахь шатанд хянасан:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР............................................ Б.МӨНХБАТ
Огноо: 2021.02.01

6417143544
ВЮА0067 9007423

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| Огноо | Аудитын нэр: | Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит | Аудитын код: |
|---|---|---|---|
| 2020 | | | БНА-2021/170/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | | Баянхонгор аймгийн Нэгдсэн эмнэлэг | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|---|---|---|---|---|---|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Тайлант онд НДХ-т 5 албан хаагчийн цалинг 4207207 төгрөгөөр илүү, 3 албан хаагчийн цалинг 1173089 төгрөгөөр дутуу буюу нийт цалингийн санг 5380296 төгрөгөөр зөрүүтэй мэдээлж 679888 төгрөгийн НДШ-ийн зардал төсвөөс илүү төлсөн байна. | 5380.3 | Албан шаардлага өгөх | Нягтлан бодогч | Д.Гантулга |
| 2 | Тайлан онд байгууллагын төсвийн захирагч нь эрчимт эмчилгээ мэдээгүйжүүлэгч жижүүр эмчийн үүрэг давхар гүйцэтгэхдээ жижүүрийн хуваарийг өөрөө баталсан байна. | - | Зөвлөмж өгөх | Дарга | Ч.Жавзан, |
| 3 | Тус байгууллагын авлагын дансны үлдэгдэл 7220.1 мянган төгрөг байгаа баа үүнээс 1936.9 мянган төгрөг нь тайлант онд үүсэн нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлсэн үлдэгдлийг оны эцэст төвлөрүүлсэнтэй холбоотой үүссэн бол 5283.8 мянган төгрөг нь 2017-2018 онуудад үүсэн 2-3 жилийн насжилттай авлагын үлдэгдэл байна. | 5283.8 | Албан шаардлага өгөх | Дарга, ерөнхий нягтлан бодогч | Ч.Жавзан, Д.Сайнбаяр |
| 4 | Кассын дансаар 2020 оны 12 дугаар сарын 25-31-ны өдрүүдэд орсон 1229.1 мянган төгрөгийн үлдэгдлийг санхүүгийн тайланд үлдэгдлээр тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ" гэсэн заалтыг зөрчсөн. | 1229.1 | Зөвлөмж өгөх | Дарга, ерөнхий нягтлан бодогч | Ч.Жавзан, Д.Сайнбаяр |
| 5 | Кассаар орлого зарлагын гүйлгээг тулган шалгахад тайланд хугацаанд нийт 59 өдрийн 30063.2 мянган төгрөгийн орлого буюу дунджаар 509.5 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийг дараагийн ажлын өдөрт багтаан төрийн сангийн дансанд төвлөрүүлээгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6 дахь заалтыг зөрчсөн байна. | 509.5 | Зөвлөмж | Дарга, ерөнхий нягтлан бодогч, нярав | Ч.Жавзан, Д.Сайнбаяр, С.Буянхишиг |
| 6 | Эрүүл мэндийн сайдын 2018 оны А/420 дугаар тушаалаар баталсан "Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамруулах журам"-ын дагуу тайлант ЭМД-ын сангаас нэмэлт дансаар 202100.0 мянган төгрөг санхүүжүүлснийг байгууллагын хамт олны хурлаар баталсан журмын дагуу 74427.0 мянган төгрөгийн алба хаагчдын урамшуулалд зарцуулж, 124869.9 мянган төгрөг буюу 61.8%-ийг тоног төхөөрөмж, эд хогшил, урсгал засвар, эргэлтийн хөрөнгө гэх мэт байгууллагын урсгал зардлыг санхүүжүүлсэн байна. | - | Зөвлөмж өгөх | Дарга, ерөнхий нягтлан бодогч | Ч.Жавзан, Д.Сайнбаяр |
| 7 | Эм, эмнэлгийн хэрэгсэл бэлтгэн нийлүүлэгч аж ахуйн нэгжүүдээс нийлүүлсэн худалдан авалтыг түүвэрлэн гэрээний үнэтэй тулган шалгахад нийт 8 аж ахуйн нэгжээс 11917ш эм эмнэлгийн хэрэгслийг гэрээний үнээс 3118280 төгрөгөөр илүү үнээр худалдан авсан байна. | 3118.3 | Төлбөрийн акт тогтоох | Нягтлан бодогч, эм зүйч | Д.Ганхүлэг, О.Жаргалмаа |
| **ДҮН** | | **15521.0** | | | |

_____oOo___